

**“ХҮННҮ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

№: 26/01

Огноо: 2026 оны 4 сарын 24

Цаг: 15:00

Хурал хуралдсан газар /хаяг, байршил/: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай Блю Скай барилгын 9 давхар.

Хурал зарлагч: Төлөөлөн Удирдах Зөвлөл

Хурлын дарга: Ц.Билэгсайхан

Хуралд оролцсон: Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, Хувьцаа эзэмшигчид, Тооллогын комиссын бүрэлдэхүүн

“Хүннү Менежмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хурлын дэгийн дагуу 15:00 цагт нээв.

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

Ц.Билэгсайхан: Өдрийн мэнд, Өнөөдрийн хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 03/01 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар М.Гантөгс даргалах байсан хэдий ч М.Гантөгс-д хүндэтгэн үзэх шалтгаан гарч хурал даргалах боломжгүй болсон тул Ц.Билэгсайхан миний бие даргална. Холбогдох ТУЗ-ийн тогтоолыг та бүхэнд танилцуулж байна. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. *(хурлын дэгийг танилцуулав.)* За ингээд хурлын дэгийн дагуу 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын ирцийн талаар мэдээлэхийг тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хүсч байна.

Тооллогын комисс: Өнөөдрийн “Хүннү Менежмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 51,802 ширхэг хувьцаанаас 26,619 ширхэг буюу 51 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал №1 “Хүннү Менежмент” ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;

Ц.Билэгсайхан: Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигч нарт танилцуулав.

Хэлэлцэх асуудал №2 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;

Ц.Билэгсайхан: Компанийн 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 06/08 дугаартай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу Компани нь 2025 онд зорилтот түвшиндээ хүрч ажиллагаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хэлэлцэх асуудал №3 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;

Ц.Билэгсайхан: Компанийн 2026 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хувыцаа эзэмшигч нарт танилцуулав.

Хэлэлцэх асуудал №4 Компанийн одоогийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх тухай

Ц.Билэгсайхан: Компанийн одоогийн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх санал гаргаж, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд П.Батбаяр, А.Азбаяр, Х.Билгүүн, Ц.Билэгсайхан, М.Ганбаатар, Г.Содбилэг хараат бус гишүүдэд Ц.Түмэнцогт, Ш.Наранцогт, Ц.Цэнд нарыг нэр дэвшүүлж байна. Нэр дэвшигчдийн холбоглох танилцуулгыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал №5 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлий бүрэлдэхүүнийг шинээр томилох тухай.

Ц.Билэгсайхан “Хүннү Менежмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчид нэр дэвшиж буй тухай холбогдох танилцуулгыг хувыцаа эзэмшигч нарт танилцуулах.

Ердийн гишүүд:

- П.Батбаяр
- Х.Билгүүн
- А.Азбаяр
- Ц.Билэгсайхан
- Г.Содбилэг
- М.Ганбаатар

Хараат бус гишүүн:

- Ц.Түмэнцогт
- Ш.Наранцогт
- Ц.Цэнд

Хэлэлцэх асуудал №4 “Хүннү Менежмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг 2026 оны зардлын төсвийг батлах

Ц.Билэгсайхан: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг танилцуулав.

АСУУЛТ, ХАРИУЛТ:

Байхгүй.

САНАЛ ХУРААЛТ:

Тооллолын комисс:

1. Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон Санхүүийн тайланд хийсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар нийт саналын эрхтэй 26,619 ширхэг буюу 51 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 26,619 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:
 - 1.1. Зөвшөөрсөн: 26,619 Ширхэг буюу 100%
 - 1.2. Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%
 - 1.3. Түдгэлзсэн: 0 Ширхэг буюу 0%
 - 1.4. Хүчингүй санал.Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай. асуудлаар нийт саналын эрхтэй 26,619 ширхэг буюу 51 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 26,619 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:
 - 2.1. Зөвшөөрсөн: 26,619 Ширхэг буюу 100%
 - 2.2. Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%
 - 2.3. Түдгэлзсэн: 0 Ширхэг буюу 0%
 - 2.4. Хүчингүй санал.Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.
3. Хурлаар хэлэлцсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд кумулятив аргаар санал өгснөөс хуралдаанд оролцсон саналын эрхтэй 26,619 ширхэг буюу 51 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 26,619 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

Нэр дэвшигч Ц.Билэгсайхан

Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй.

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч М.Ганбаатар

Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Г.Содбилэг

Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Х.Билгүүн

Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч П.Батбаяр
Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%
Татгалзсан: Байхгүй
Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч А.Азбаяр
Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%
Татгалзсан: Байхгүй
Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Ц.Түмэнцогт
Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%
Татгалзсан: Байхгүй
Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Ш.Наранцогт
Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%
Татгалзсан: Байхгүй
Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Ц.Цэнд
Зөвшөөрсөн: 26,619 ширхэг буюу 100%
Татгалзсан: Байхгүй
Түдгэлзсэн: Байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8 дахь хэсэгт зааснаар нэр дэвшигчид Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдож, шийдвэр хүчинтэй.

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний 2026 оны зардлыг төсвийг батлах тухай. асуудлаар нийт саналын эрхтэй 26,619 ширхэг буюу 51 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 26,619 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

- 4.1. Зөвшөөрсөн: 26,619 Ширхэг буюу 100%
- 4.2. Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%
- 4.3. Түдгэлзсэн: 0 Ширхэг буюу 0%
- 4.4. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

Ц.Билэгсайхан: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

1. Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр томилох;

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг тус тус хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг үндэслэн хэлэлцэн батлав.

ХУРЛЫН ХААЛТ:

Ц.Билэгсайхан: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан,

Хурлын дарга Ц.Билэгсайхан

Тэмдэглэл хөтөлсөн,

Ц.Номинцэцэг:

